



БАТЛАВ
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ *Н.ЦОГБАДРАХ*

2018 ... оны ... сарын ... өдөр

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЭМЧ АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Энэхүү эмч ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн зорилго нь Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон эмч ажилтнуудыг сэтгэл ханамжтай, тогтвортой суурьшилтай ажиллуулах, ээлтэй ажлын орчин нөхцөлөөр ханганд нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оршино.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, нийслэлийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлсний талаар мөрдөгдөж буй Засгийн Газрын тогтоол, Эрүүл мэндийн яам, МЭМЯУЭХ-ны хамтран баталсан “Эрүүл мэндийн салбарын хамтын хэлэлцээр”, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээ зэрэг нь эмч ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэс болно.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- 3.1. Цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох
 - 3.1.1. Эмч ажилтнуудын ажлын байрны зураг авалтаар ажлын ачаалал, хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн тусlamж үйлчилгээний онцлогыг судалж үнэлжэх
 - 3.1.2. Эмч ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоог шинэчлэх боломжийг судлан холбогдох байгууллагад санал хүргэх, байгууллагын дотоодын нөөц боломжийг судлан хэрэгжүүлэх
 - 3.1.3. Мөнгөн ба мөнгөн бус урамшууллын шинэлэг тогтолцоог нэвтрүүлэн ажлын бүтээмжийг дээшлүүлэх хэрэгсэл болгох

3.2. Эрүүл, аюулгүй, ээлтэй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх

- 3.2.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх эмч ажилтнуудын мэдлэг сайжруулах сургалт, сурталчилгааны ажлыг жил бүр зохион байгуулах
- 3.2.2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчний судалгаа, шалтгааныг судлан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах
- 3.2.3. Ажлын байрны тохь тухтай, таатай орчин нөхцөлийг бий болгоход анхааран засвар тохижилтийг шаардлагатай тасаг нэгжид хийх, тавилга хэрэгслээр хангах
- 3.2.4. Ажлын байранд алжаал тайлах, дасгал хөдөлгөөн хийх, чанартай, эрүүл хоолоор үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх

3.3. Эмч ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах

- 3.3.1. Эмч ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих арга хэмжээг жил бүр хэрэгжүүлж үр дүнг тооцох
- 3.3.2. Эмч ажилтнуудын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, хөдөлмөрийн чадвар түр алдалтыг судлан бууруулах бодлого боловсруулан хэрэгжүүлэх
- 3.3.3. Эмч ажилтны эрүүлжилтийн үр дүнг тооцох: эрүүл, эрүүлжсэн ажилтныг урамшуулах хөдөлгөөн өрнүүлэх

3.4. Нийгмийн баталгааны бусад асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

- 3.4.1. Төрийн албан хаагчдын орон сууцны зээлд эмч ажилтнуудыг хамруулахад дэмжлэг үзүүлэх, зуучлах
- 3.4.2. Эмч ажилтнуудын орон сууц барих, зуслангийн газар авах зэрэг асуудлаар холбогдох байгууллагуудад санал тавьж шийдвэрлүүлэх
- 3.4.3. Хүүхдийн өдөр өнжүүлэх ангийг байгууллага дээрээ ажиллуулах нөхцөл боломжийг судлан хэрэгжүүлэх
- 3.4.4. Урлаг спорт, экологи, эрүүл мэнд, залуучуудын гэх мэт олон нийтийн арга хэмжээг хамт олныг идэвхжүүлэх хэрэгсэл болгон зохион байгуулах

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

- Хөтөлбөрт Эрүүл мэндийн төвийн бүх тасаг, клиникийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд хамрагдана.
- Хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлнэ.
- Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг ҮЭХ, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын санхүүжилт, хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн

- 5.1.1. Эмч ажилтны нийгмийн баталгааны асуудлууд шийдэгдснээр сэтгэл ханамжтай, тогтвортой суурьшилтай ажиллах эмч ажилтны тоо нэмэгдэнэ.
- 5.1.2. Эмч ажилтнуудын эрүүл мэндийн индекс сайжран хөдөлмөрийн чадвар түр алдалт багасна.
- 5.1.3. Эмч ажилтнуудын бүтээлч хандлага сайжирч, нэгэн зорилгод чиглэсэн хамт олны уур амьсгал сайжирна.
- 5.1.4. Эмч ажилтнуудын сэтгэл ханамж дээшилснээр тусламж үйлчилгээний чанар сайжирна.

5.2. Хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлт

- 5.2.1. Нэмэгдэл цалингийн хувь, хэмжээ
- 5.2.2. Урамшуулал, хөнгөлөлтийн төрөл, хамрагдсан ажилтны тоо, эзлэх хувь
- 5.2.3. Орон сууцтай болсон, орон сууцны нөхцөлөө сайжруулсан ажилтны тоо, эзлэх хувь
- 5.2.4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны тоо, эзлэх хувь
- 5.2.5. Эрүүл, эрүүлжсэн ажилтны тоо, эзлэх хувь
- 5.2.6. Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тоо, эзлэх хувь
- 5.2.7. Орчин нөхцлийг сайжруулсан ажлын байрны тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ
- 5.2.8. Эмч ажилтнуудын нийгмийн баталгаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ